



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/08-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)  
Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)  
Ахлах аудитор П.Цэцэгдулам  
Цахим хаяг: [Tsetsegdulamp@audit.gov.mn](mailto:Tsetsegdulamp@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>12</b>
<b>5.1 Албан шаардлага .....</b>	<b>12</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>13</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.08.25 № 160  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА П.АЛТАНХУЯГ  
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн доорх алдаа зөрчил нь материаллаг боловч санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь өргөн тархаагүй тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 280,035.1 мянган төгрөгийн 19 төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй.
2. Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд тусгагдсан 312,069.1 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, зээлдэгчдийн бүртгэл, мэдээлэл зөрүүтэй, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй зээлийн үлдэгдлийг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан.
3. Тайланд онд мэдээлбэл зохих 21 мэдээллийг хугацаа хоцроож, 15 мэдээллийг Шилэн дансанд байршуулаагүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 8.4, 18.1, Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.1, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 11.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.1 дэх заалтыг зөрчсөн, аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 86.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,456,522.6	1,837,310.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,040,442.8	1,439,395.9
33	АВЛАГА	320,687.5	312,069.1
35	БАРАА МАТЕРИАЛ	72,618.2	85,845.6
36	НӨӨЦИЙН БАРАА	22,774.2	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,798,309.2	1,593,898.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,798,309.2	1,593,898.4
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	1,779,853.8	1,575,806.4
39300	Биет бус хөрөнгө	18,455.3	18,092.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,254,831.7	3,431,209.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,254,831.7	3,431,209.1
51	Засгийн газрын хувь оролцоо	3,254,831.7	3,431,209.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	527,026.4	527,026.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,495,594.9	2,671,972.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	232,210.4	232,210.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,254,831.7	3,431,209.1

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,776,549.8	1,951,288.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	844,640.5	746,209.2
110	Орлогын албан татвар	250,122.0	294,226.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	250,065.3	294,100.7
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	56.7	126.0
113	Хөрөнгийн албан татвар	155,737.7	131,568.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	438,780.8	320,414.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	494,105.4	358,182.4
120	Нийтлэг татварын бус орлого	494,105.4	358,182.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,437,803.8	846,896.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,946,754.4	1,332,625.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,946,754.4	1,332,625.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964,603.2	1,317,454.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370,137.7	499,194.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,502.7	63,542.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,152.5	16,311.6
2104	Хангамж, бараа материалын зардал	14,120.9	75,999.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,895.6	9,515.6
2107	Томилолт, зочны зардал	5,861.6	6,900.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,006.0	139,046.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,926.2	506,944.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	982,151.3	15,171.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	829,795.3	618,662.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,580,060.3	442,285.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,750,265.0	176,377.4

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,433,299.8	2,024,560.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	844,640.5	746,209.2
110	Орлогын албан татвар	250,122.0	294,226.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	250,065.3	294,100.7
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	56.7	126.0
113	Хөрөнгийн албан татвар	155,737.7	131,568.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	438,780.8	320,414.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,455.8	23,626.9
1181	Газрын төлбөр	67.4	10,758.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	428,257.6	286,028.8
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,855.4	431,454.6
120	Нийтлэг татварын бус орлого	150,855.4	431,454.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,437,803.8	846,896.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,680,329.2	1,037,172.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,680,329.2	1,037,172.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	696,062.8	1,022,000.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,983.7	500,983.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,606.7	61,753.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,940.1	16,040.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,826.3	54,035.2
2105	Нормативт зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,456.6	9,365.6
2107	Томилолт, зочны зардал	3,861.6	6,900.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,306.5	143,752.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,081.3	229,170.6
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	984,266.3	15,171.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	752,970.6	987,388.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	218,241.8	478,085.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	218,241.8	478,085.0
2200	Дотоод эх үүсвэрээр	218,241.8	478,085.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-218,241.8	-478,085.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-200,000.0	-110,349.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.0	110,349.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	334,728.8	398,953.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	705,713.9	1,040,442.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,040,442.8	1,439,395.9

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,179,350.9	7,179,350.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-174,254.2	-174,254.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,005,096.7	7,005,096.7
9	Тайлант үеийн үр дүн	-3,750,265.0	-3,750,265.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,254,831.7	3,254,831.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,254,831.7	3,254,831.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,254,831.7	3,254,831.7
19	Тайлант үеийн үр дүн	176,377.4	176,377.4
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,431,209.1	3,431,209.1

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,429,214.9	1,620,981.2	808,233.7	66.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,203,723.5	1,062,346.4	141,377.1	88.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,188,551.6	1,047,175.0	141,376.6	88.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,397.7	500,983.3	10,414.4	98.0
210101	Үндсэн цалин	490,097.7	354,963.9	135,133.8	72.4
210102	Нэмэгдэл	-	95,277.7	(95,277.7)	-
210104	Урамшуулал	-	37,941.8	(37,941.8)	-
210105	Гэрээт ажлын хөлс	21,300.0	12,800.0	8,500.0	60.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,174.7	61,753.1	3,421.6	94.8
210201	Тэтгэврийн даатгал	44,718.8	43,084.7	1,634.1	96.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,114.0	5,068.8	45.2	99.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,091.1	4,002.2	88.9	97.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,022.8	856.2	166.6	83.7
210205	Эрүүл мэндийн даатгал	10,228.0	8,741.2	1,486.8	85.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,791.8	97,801.5	2,990.3	97.0
210301	Гэрэл, цахилгаан	37,893.8	35,253.5	2,640.3	93.0
210302	Түлш, халаалт	62,190.0	62,190.0	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	708.0	358.0	350.0	50.6
2104	Хангамж, бараа материалын зардал	53,096.4	53,087.1	9.3	100.0
210401	Бичиг хэрэг	8,186.0	8,185.2	0.8	100.0
210402	Тээвэр, шатахуун	33,500.0	33,491.5	8.5	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,550.0	5,550.0	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,860.4	5,860.4	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,484.4	21,484.1	0.3	100.0
210604	Урсгал засвар	21,484.4	21,484.1	0.3	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,700.0	6,900.3	1,799.7	79.3
210702	Дотоод албан томилолт	8,700.0	6,900.3	1,799.7	79.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,120.0	46,195.1	10,924.9	80.9

Архангай аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,700.0	40,695.1	10,004.9	80.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	920.0	-	920.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500.0	500.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000.0	5,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	370,786.6	258,970.6	111,816.0	69.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	366,786.6	254,971.0	111,815.6	69.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000.0	3,999.6	0.4	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,171.9	15,171.4	0.5	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,171.9	15,171.4	0.5	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,171.9	15,171.4	0.5	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	934,091.4	448,285.0	485,806.4	48.0
222001	Тоног төхөөрөмж	6,000.0	6,000.0	-	100.0
223001	Бусад хөрөнгө	928,091.4	442,285.0	485,806.4	47.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	291,400.0	110,349.8	181,050.2	37.9
230001	Эргэж төлөгдөх зээл	291,400.0	110,349.8	181,050.2	37.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,429,214.9	1,628,148.9	801,066.0	67.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,261,767.9	1,508,686.9	(246,919.0)	119.6
320001	Орон нутгийн төсвөөс	885,033.6	1,131,952.6	(246,919.0)	127.9
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	376,734.3	376,734.3	-	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,167,447.0	119,462.0	1,047,985.0	10.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	293,170.0	119,462.0	173,708.0	40.7
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	874,277.0	-	874,277.0	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	396,817.5	(396,817.5)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	403,985.2	(403,985.2)	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	28.00	0.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,625,875.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,625,875.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,625,875.00
2104	Хангамж, бараа материалын зардал	948,096.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,677,779.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,625,875.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,625,875.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 249,318.1 мянган төгрөгийн залруулга хийлээ. Залруулагдаагүй нийт **592,104.2** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчил арилгуулах 2, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлээ.

### Залруулга:

Тайлант оны ОНХС-ийн гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 20,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, ХХС-аас тайлант онд олгосон 110,349.8 мянга төгрөгийн зээл, 118,968.2 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахгүй орхигдуулсныг аудитын явцад залрууллаа.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд тусгагдсан 312,069.1 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэл нь үнэн зөв тусгагдсан эсэх нь тодорхойгүй, аудитын хугацаанд ирүүлсэн судалгаа, бүртгэлийн программын мэдээлэл зөрүүтэй, зээлийн бүртгэл, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ын 5.1.4. үнэн зөв байх, 8.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох, зээлийн үлдэгдлийг насжилтаар нь зөв ангиалан бүртгэн, авлагыг үнэн зөв тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ.*

5.1.2 Тайлант онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 280,035.1 мянган төгрөгийн 19 төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Сангийн сайдын 86 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.1 “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох, хөрөнгийг бүртгэл тайланд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мэдээллийг зөрүүтэй, тусгахгүй орхигдуулсан	3	249,318.1	2	229,318.0	1	20,000.0	3	249,318.1				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС-ийн зээлийн авлага зөрүүтэй	1	312,069.1			1	312,069.1						
Бүртгэлд тусгаагүй	1	280,035.1			1	280,035.1						
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>592104.2</b>			<b>2</b>	<b>592104.2</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлж ажиллаагүй	1	0			1	0						